

7/21 - 2011 орс
(3x) 121



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2011 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 416

Улаанбаатар хот

Сургалтын төрийн сангийн зээлээр
гадаадад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 177 дугаар тогтоолын тавдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захиалгаар Эрдэнэбаяр Овогтой Содбилэгийг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Зийгэн /Siegen/ их сургуулийн магистрантурт Бүтцийн шинжилгээ чиглэлээр 1.5 жилийн, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захиалгаар Батсайхан овогтой Танхилсайханыг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Зийгэн /Siegen/ их сургуулийн магистрантурт Цацраг идэвхит элементийн боловсруулалт чиглэлээр 1.5 жилийн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын захиалгаар Наран овогтой Тунгалагийг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Зийгэн /Siegen/ их сургуулийн магистрантурт Ашигт малтмалын боловсруулалтын чиглэлээр 1.5 жилийн, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захиалгаар Бат-Эрдэнэ овогтой Батбилэгийг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Зийгэн /Siegen/ их сургуулийн магистрантурт Структур геологи, нанотехнологийн чиглэлээр 1.5 жилийн, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны захиалгаар Жанрай овогтой Сонинбаярыг Нидерланд Улсын Твенте /Twente/ их сургуулийн магистрантурт Ус судлал, гидротехникийн чиглэлээр 1.5 жилийн, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны захиалгаар Цэнджав овогтой Эрдэнэбаярыг Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Йорк /York/ их сургуулийн магистрантурт Байгаль орчны стратеги төлөвлөлт, тогтвортой хөгжлийн чиглэлээр 2 жилийн, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны захиалгаар Бавуудорж овогтой

1100742

Ганбатыг Нидерланд Улсын Твенте /Twente/ их сургуулийн магистрантурт Байгаль орчны стратеги төлөвлөлт, тогтвортой хөгжлийн чиглэлээр 1.5 жилийн, Эрүүл мэндийн яамны захиалгаар Батчулуун овогтой Батцоожыг Америкийн Нэгдсэн Улсын Страйер /Strayer/ их сургуулийн магистрантурт Эрүүл мэндийн эдийн засаг чиглэлээр 2 жилийн, Эрүүл мэндийн яамны захиалгаар Ганболд овогтой Мөнхзулыг Бүгд Найрамдах Франц Улсын Парис Дидеро /Paris Diderot/ их сургуулийн магистрантурт Хоол тэжээл хүнсний аюулгүй байдал чиглэлээр 2 жилийн, Сангийн яамны захиалгаар Дүгэрсүрэн овогтой Оюунтуяаг Америкийн Нэгдсэн Улсын Линкольн /Lincoln/ их сургуулийн магистрантурт Уул уурхайн татвар чиглэлээр 1.5 жилийн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Цээлхаажав овогтой Баярмөнхийг Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Лондон /London/ их сургуулийн магистрантурт Боловсролын агуулга стандартын чиглэлээр 2 жилийн, Сангийн яамны захиалгаар Тэрбиш овогтой Золжаргалыг Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Вэстминстер /Westminster/ их сургуулийн магистрантурт Санхүү, эдийн засагчийн чиглэлээр 1 жилийн, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны захиалгаар Рэнцэнханд овогтой Отгонжаргалыг Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Ийст Лондон /East London/ их сургуулийн магистрантурт Олон улсын харилцааны чиглэлээр 1 жилийн, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын захиалгаар Буянхишиг овогтой Мөнхзаяаг Нидерландын Вагенинген /Wageningen/ их сургуулийн магистрантурт Хөгжлийн эдийн засгийн чиглэлээр 2 жилийн, Зам тээвэр, барилга хот байгуулалтын яамны захиалгаар Баттулга овогтой Алтаншагайг Америкийн Нэгдсэн Улсын Жорж Вашингтон /George Washington/ их сургуулийн магистрантурт Санхүүгийн менежментийн чиглэлээр 2 жилийн, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Цээбаатар овогтой Алтайхүүг Америкийн Нэгдсэн Улсын Американ /American/ их сургуулийн магистрантурт Бизнесийн эрхзүйн чиглэлээр 2 жилийн, Сангийн яамны захиалгаар Цэвээндээ овогтой Билгүүнийг Бүгд Найрамдах Солонгос Улсын Кореа/Korea/ их сургуулийн магистрантурт Эдийн засагч чиглэлээр 2 жилийн, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын захиалгаар Пүрэвдорж овогтой Мөнхсэлэнгийг Америкийн Нэгдсэн Улсын Уэйк Форест /Wake Forest/ их сургуулийн магистрантурт Эрхзүйн чиглэлээр 1 жилийн, Соёл урлагийн их сургуулийн захиалгаар Төмөр-Очир овогтой Болорыг Швед Улсын Малмoe /Malmoe/ хөгжмийн дээд сургуулийн магистрантурт Хийлийн чиглэлээр 1 жилийн, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн

төлөө газрын захиалгаар Балсандорж овогтой Азжаргалыг Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант улсын Астон /Aston/ их сургуулийн магистрантурт Бизнесийн удирдлагын чиглэлээр 1 жилийн, Мэдээлэл шуудан, харилцаа холбоо, технологийн газрын захиалгаар Батсүрэн овогтой Амгаланбатыг Япон Улсын Кьюшю /Kyushu/ Технологийн дээд сургуулийн докторантурт Сансрын технологийн чиглэлээр 3 жилийн, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захиалгаар Батсайхан овогтой Баяртунгалагийг Бүгд Найрамдах Солонгос Улсын Кореа /Korea/ их сургуулийн докторантурт Газарзүйн мэдээллийн систем ба зайнаас тандан судлах чиглэлээр 3 жилийн, Шинжлэх ухааны академийн захиалгаар Алтансүвд овогтой Жавхлантауяаг Япон Улсын Токиогийн Хөдөө аж ахуйн их сургуулийн докторантурт Хөрс судлал чиглэлээр 3 жилийн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын захиалгаар Шархүү овогтой Мөнхбатыг Бүгд Найрамдах Солонгос Улсын Кюн Хий /Kyoung Hee/ их сургуулийн докторантурт Төрийн бодлого, удирдлагын чиглэлээр 3 жилийн, Эрүүл мэндийн яамны захиалгаар Гантөмөр овогтой Энхбилэгийг Австри Улсын Вена /Vienna/ анагаах ухааны их сургуулийн докторантурт Дархлаа судлалын чиглэлээр 3 жилийн, Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны их сургуулийн захиалгаар Норжмаа овогтой Батчимэгийг Япон Улсын Гунма /Gunma/ их сургуулийн докторантурт Клиникийн биохими, кибернетикийн чиглэлээр 3 жилийн, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн захиалгаар Батбаатар овогтой Алзахгүйг Австри Улсын Вена /Vienna/ их сургуулийн докторантурт Дотоод шүүрлийн чиглэлээр 3 жилийн хугацаатайгаар сургалтын төрийн сангийн зээлээр тус тус суралцуулсугай.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД



Ё.ОТГОНБАЯР